



ӨМНӨГОВЬ АЙМАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2018 оны 04 сарын 19 өдөр

Дугаар A/17

Даланзадгад

Хуваарь батлах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалт, аймгийн Засаг даргын 2017 оны А/1344 дүгээр захирамжийн 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- Сум дундын эмнэлэг, сумын эрүүл мэндийн төвүүдийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн дэмжлэгээр хангаж ажиллах хуваарийг нэгдүгээр хавсралт, үйл ажиллагааны чиглэлийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
- Тухайн хуваарилагдсан байгууллагын эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд мэргэжил арга зүйн дэмжлэгээр хангаж ажиллахыг хэлтсийн дарга, мэргэжилтнүүдэд үүрэг болгосугай.
- Эмнэлэг, эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааг сайжруулахад хариуцсан албан тушаалтантай хамтран үр дүнтэй ажиллахыг Сум дундын эмнэлэг, Эрүүл мэндийн төвийн дарга, эрхлэгч наарт үүрэг болгосугай.
- Тухайн ажлын явц, тайлан, үр дүнд үнэлгээ дүгнэлт хийж, зөвлөмжөөр хангаж ажиллахыг хяналт шинжилгээ үнэлгээний мэргэжилтэн /С.Сарантунгалаг/-д даалгасугай.

ДАРГА

Ц.ӨНӨРЖАРГАЛ



Эрүүл мэндийн газрын даргын
2018 оны 04 дугээр сарын 19-ний өдрийн
A/17 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



**СУМ ДУНДЫН ЭМНЭЛЭГ, СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВҮҮДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ
МЭРГЭЖИЛ, АРГА ЗҮЙГЭЭР ХАНГАЖ АЖИЛЛАХ ХУВААРЬ**

Д/д	Сумын нэр	Хариуцсан албан хаагчийн нэр	Албан тушаалын нэр
1	Баяндалай сумын ЭМТөв	Д.Сэлэнгэ	Эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж хариуцсан мэргэжилтэн
2	Баян-Овоо сумын ЭМТөв	Б.Хатантуул	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер
3	Булган сумын ЭМТөв	М.Булганчимэг	Нийгмийн эрүүл мэндийн төвийн дарга
4	Гурвантэс сумын ЭМТөв	М.Цэндсүрэн	Удирдлага, төлөвлөлт санхүүгийн хэлтсийн дарга
5	Манлай сумын ЭМТөв	С.Сарантунгалаг	Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтэн
6	Мандал-Овоо сумын ЭМТөв	Б.Мидэрсүрэн	Хяналт шинжилгээ үнэлгээ мэдээллийн хэлтсийн дарга
7	Ноён сумын Сум дундын эмнэлэг	Б.Ганцэцэг	Өсвөр үе, сэтгэцийн эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн
8	Номгон сумын ЭМТөв	Б.Машбаяр Б.Баасансүрэн	Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, Хоол тэжээлийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд
9	Сэврэй сумын ЭМТөв	Д.Гантоотох	Эрүүл мэндийн мэдээллийн сан хариуцсан бага эмч
10	Ханбогд сумын Сум дундын эмнэлэг	Д.Дүүмаам Г.Мөнхжаргал	Сувилахуйн тусламж үйлчилгээний чанар, ХБӨ-ний асуудал хариуцсан мэргэжилтнүүд
11	Ханхонгор сумын ЭМТөв	Б.Бямбажав	Халдварт өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн
12	Хүрмэн сумын ЭМТөв	Г.Мөнхзул Д.Батдэлгэр	Дархлаажуулалтын нөөц хариуцсан, Мэдээлэл технологийн мэргэжилтнүүд
13	Цогт-Овоо сумын ЭМТөв	С.Даваасүрэн	Нийтийн биеийн тамир, чийрэгжүүлэлт хариуцсан мэргэжилтэн
14	Цогтцэций сумын Сум дундын эмнэлэг	Ж.Отгонбайгал	Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хэлтсийн дарга
15	Цогтцэций Энэрэхүй-Ухаан өрхийн ЭМТөв	Б.Мэндбаяр Ц.Мандах	Эмийн чанар аюулгүй байдал, Хүний нөөц хариуцсан мэргэжилтнүүд

Эрүүл мэндийн газрын даргын
2018 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн
A/17 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

СҮМ ДУНДЫН ЭМНЭЛЭГ, СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВҮҮДИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААГ МЭРГЭЖИЛ, АРГА ЗҮЙГЭЭР ХАНГАЖ АЖИЛЛАХ ЧИГЛЭЛ

Нийтлэг үндэслэл:

Аймгийн хэмжээнд Сум дундын 3 эмнэлэг, сумын 11 Эрүүл мэндийн төв, сумын 1 өрхийн Эрүүл мэндийн төв үйл ажиллагаагаа явуулж байна. Суманд үйл ажиллагаа явуулж буй эмнэлэг, Эрүүл мэндийн төвүүд нь Даланзадгад sumaас газар зүйн алслагдмал байршилтайгаас шалтгаалан тухайн эмнэлэгт тогтмол хүрч ажиллах боломж хязгаарлагдмал байдаг. Эрүүл мэндийн газрын хяналт, шинжилгээ, үнэлгээний баг жилдээ 1-2 удаа Сум дундын эмнэлэг, Эрүүл мэндийн төвүүдэд хүрч ажилладаг.

Иймээс тухайн сумын эмнэлгийн тусlamж үйлчилгээ, үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйгээр тогтмол хангах, сумын засаг захиргаа, эмнэлэг, эрүүл мэндийн төвийн удирдлагуудтай хамтран ажиллах шаардлагын улмаас эмч, мэргэжилтэнүүдэд сумдыг хуваарилж, чиглэлийг гаргаж байна.

Зорилго: Эрүүл мэндийн газрын эмч, мэргэжилтэнүүд хариуцсан сумын Эрүүл мэндийн төв, Сум дундын эмнэлгийн үйл ажиллагааг мэргэжил арга зүйгээр дэмжин ажиллаж, тусlamж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах


Хариуцсан мэргэжилтнүүд доорх үйл ажиллагааны чиглэлээр мэргэжил арга зүйн дэмжлэгээр ханган хамтран ажиллана. Үүнд:

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр:

- Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого болон байгууллагын хэтийн төлөвлөлт, хэрэгжилтийг эрчимжүүлэх арга зүйгээр хангах
- Сумын Засаг даргатай байгуулсан гэрээний гүйцэтгэлд хяналт тавих
- Тухайн сумын эрүүл мэндийн статистик мэдээлэлд дүн шинжилгээ хийж, тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, Эрүүл мэндийн газрын удирдлагын багт танилцуулах
- Тухайн байгууллагын удирдлагын багийн үйл ажиллагааг чиглүүлэх
- Хяналт, шинжилгээ үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилт
- Байгууллагын хамтын ажиллагаа, багийн зохион байгуулалт, эвсэг нийтэч хамт олон бий болгоход дэмжиж ажиллах
- Албан хэрэг хөтлөлтийн байдалд зөвлөмж өгөх

Хоёр. Нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээний чиглэлээр:

- Засгийн газрын болон Засаг даргын мөрийн хөтөлбөр, үндсэн чиглэлийн хэрэгжилт
- Үндэсний болон аймгийн хөтөлбөр, стратеги, тогтоол, захирамжийн хэрэгжилт, үр дүнг тооцох



- Эрүүл мэндийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх
- Тухайн нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндийн байдалд нөлөөлж буй сөрөг хүчин зүйл, түүний нөлөөлөл, авч хэрэгжүүлж буй арга хэмжээнд хяналт тавих
- Иргэдийн дунд халдварт бус өвчний эрт илрүүлэг, үзлэг шинжилгээ, урьдчилан сэргийлэх арга хэмжээний хувь, үр дүн, хяналт, эрүүлжүүлэлтийн байдалд үнэлгээ хийх
- Халдварт өвчнөөс сэргийлэх, дархлаажуулалтыг чанаржуулах
- Хүн амын зөв хооллолт, дасгал хөдөлгөөний байдал
- Хүүхэд, өсвөр үе, ахмад, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэндийн байдал, тусlamж үйлчилгээний хүртээмжид үнэлгээ хийх, зөвлөмжөөр хангах
- Эрүүл мэндийг дэмжих, иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зан үйлийн төлөвшүүлэхэд арга зүйгээр хангах
- Байгууллага, хамт олон, иргэдийн хамтын ажиллагааг сайжруулах
- Хүн амын эрүүл мэндийн нэгдсэн сан, судалгаатай болоход дэмжлэг үзүүлэх
- Иргэдэд ээлтэй эмнэлэг, эрүүл мэндийн төв, эрүүл мэндийг дэмжигч байгууллага болоход дэмжлэг үзүүлэх

Гурав. Эмнэлгийн тусlamж үйлчилгээг сайжруулах чиглэлээр:

- Сум дундын эмнэлэг, эрүүл мэндийн төвийн стандарт хангарт, түүнийг хэрэгжүүлэх
- Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний багц, удирдамжийн хэрэгжилтэд хяналт тавих, мэргэжлийн арга зүйгээр хангах
- Эмнэлгийн тусlamж үйлчилгээний чанар, хүртээмж, үр дүн, үр нөлөөг дээшлүүлэх
- Чанарын алба, чанарын хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах
- Тухайн сумын иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг авч, үнэлгээ дүгнэлт хийж, түүний мөрөөр авч хэрэгжүүлж буй арга хэмжээнд хяналт тавих
- Тусlamж үйлчилгээнд тулгамдсан асуудлыг шийдвэрлүүлэхэд удирдлага, холбогдох мэргэжилтнүүдийн дэмжлэг туслалцааг авах

Дөрөв. Хүний нөөцийн чиглэлээр:

- Тухайн байгууллагын хүний нөөцийн стандарт хангарт, хөгжил, сургалтын байдалд үнэлгээ, зөвлөмжөөр хангах, сургах асуудлыг шийдвэрлүүлэх
- Хүний нөөцийн ойрын болон хэтийн төлөвлөлтийн хэрэгжилтэд хяналт тавих
- Байгууллагын “Ёс зүйн алдаа доголдлоос сэргийлэх төлөвлөлт”-д хяналт тавих, арга зүйгээр хангах

Хариуцсан сумын үйл ажиллагаанд үнэлгээ, дүгнэлт хийж, үйл ажиллагааг сайжруулах төлөвлөлтийг хийн, зохион байгуулсан ажлаа жил бүрийн 12 дугаар сарын 10-ний дотор Хяналт шинжилгээ үнэлгээний мэргэжилтэн авч үнэлж, Эрүүл мэндийн газрын удирдлагын багаар үнэлгээг хэлэлцүүлнэ.

----- О -----